

## ТАНИЛЦУУЛГА

*Дүрэм шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3-т “Нийгмийн даатгалын байгууллагын болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ажил олгогч, даатгуулагч нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллага хооронд гарсан саналын зөрөөг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрмийг Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталж, өнөөдрийг хүртэл 28 жил мөрдөж байна.

Дээрх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нэлээдгүй өөрчлөлт орсон.

Мөн дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой баталсан тогтоол, тушаал, дүрэм, журмуудыг шинэчлэн баталсан, мөн нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбоотой ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын байгууллага хоорондын саналыг зөрөөг хянан шийдвэрлэх Зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах шаардлагатай байна.

Дүрмийн төсөлд зөвлөлийн ажиллах зарчим, Гомдлын шаардлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг бүртгэх мэдээллийн нэгдсэн цахим сан, зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалт, гишүүдэд тавигдах шаардлага, ажил олгогч, даатгуулагчаас ирүүлсэн гомдлыг хянан үзэх үйл ажиллагаа, төв зөвлөл болон салбар зөвлөлийн эрх, үүргийн талаар тодорхой болгож зохицуулсан.

2020 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөл 7 удаа, аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн Гомдлын шаардлагын зөвлөл нийт 152 удаа тус тус хуралдсан байна.

Мөн тогтоолын төсөлд Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолыг хүчингүй болгохоор тусгасан болно.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ